

Анагаах ухааны практикт шинээр нэвтрүүлсэн технологийн мэдээллийн санд Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн 8 буюу нийт хамрагдвал зохих эрүүл мэндийн байгууллагын 62% нь мэдээлэл ирүүлсэн байна.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагууд

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр
1	Улсын гуравдугаар төв эмнэлэг
2	Цус сэлбэлт судлалын үндэсний төв
3	Хавдар судлалын үндэсний төв
4	Геронтологийн үндэсний төв
5	Арьсны өвчин судлалын Геронтологийн үндэсний төв
6	Эмгэг судлалын үндэсний төв
7	Зоонозын өвчин судлалын үндэсний төв
8	Халдварт өвчин судлалын үндэсний төв

Нийт 8 эрүүл мэндийн байгууллагад сүүлийн 5 жилийн хугацаанд нийт 191 шинэ технологи нэвтрүүлсэн байна. Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв зэрэг байгууллага нь судалгааны мэдээлэл ирүүлээгүй болно.

Хүснэгт 2. Сүүлийн 5 жилийн хугацаанд эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлсэн технологийн тоо, тэдгээрийн эзлэх хувь

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Нэвтрүүлсэн технологи	
		Тоо	Хувь
1	Улсын гуравдугаар төв эмнэлэг	54	28.3
2	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	18	9.4
3	Хавдар судлалын үндэсний төв	40	21
4	Геронтологийн үндэсний төв	15	7.9
5	Арьсны өвчин судлалын үндэсний төв	18	9.4
6	Эмгэг судлалын үндэсний төв	15	7.9
7	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	13	6.7
8	Халдварт өвчин судлалын үндэсний төв	18	9.4
	Нийт	191	100

Судалгаанд хамрагдсан байгууллагуудаас хамгийн олон технологи шинээр нэвтрүүлсэн байгууллага нь Улсын гуравдугаар төв эмнэлэг байсан ба 54 технологи нэвтрүүлсэн нь нийт нэвтрүүлсэн технологийн 28.3%-ийг эзэлж байна. Хавдар судлалын үндэсний төв 40 технологи нэвтрүүлсэн нь нийт нэвтрүүлсэн технологийн 21%-ийг эзэлснээр удаалж байна. Зоонозын өвчин судлалын үндэсний төв сүүлийн 5 жилийн хугацаанд хамгийн бага буюу 13 технологийн эрүүл мэндийн практикт нэвтрүүлжээ.

Хүснэгт 3. Шинээр нэвтрүүлсэн технологийн төрөл

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Нэвтрүүлсэн технологийн төрөл				
		Шинэ эм	Вакцин	Шинэ эмнэлгийн тоног	Мэс заслын шинэ	Бусад

				төхөөрө мж	арга	
1	Улсын гуравдугаар төв эмнэлэг	-	-	20	34	-
2	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	-	-	16	-	2
3	Хавдар судлалын үндэсний төв	21	-	3	9	7
4	Геронтологийн үндэсний төв	-	-	14	-	1
5	Арьсны өвчин судлалын үндэсний төв	-	-	-	-	18
6	Эмгэг судлалын үндэсний төв	-	-	13	-	2
7	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	-	-	3	-	10
8	Халдварт өвчин судлалын үндэсний төв	3	3	8	3	1
	Нийт					
	Тоо	24	3	77	46	41
	Хувь	12.6	1.6	40.3	24.1	21.4

Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлсэн шинэ технологийн дийлэнх нь буюу 40,3%(77) нь эмнэлгийн тоног төхөөрөмж, 46 буюу 24,1 % нь мэс заслын арга, эмчилгээнд шинээр нэвтрүүлсэн эм 12,6%, вакцин 1,6%, бусад нь 21.4%-ийг тус тус эзэлж байна. Шинээр нэвтрүүлсэн бусад технологид шинжилгээ, оношилгоо, үнэлгээний шинэ арга,аргачлал, заавар зэрэг орж байна.

Шинээр нэвтрүүлсэн технологийн 37%-д нь эрүүл мэндийн байгууллага үнэлгээ хийсэн байна.

Хүснэгт 4.Технологийн үнэлгээ хийгдсэн байдал

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Нэвтрүүлсэн технологийн тоо	Үүнээс үнэлгээ хийгдсэн технологийн тоо	
			Тоо	Хувь
1	Улсын гуравдугаар төв эмнэлэг	54	-	-
2	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	18	16	89
3	Хавдар судлалын үндэсний төв	40	3	7.5
4	Геронтологийн үндэсний төв	15	14	93.3
5	Арьсны өвчин судлалын үндэсний төв	18	14	78
6	Эмгэг судлалын үндэсний төв	15	15	100
7	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	13	-	-
8	Халдварт өвчин судлалын үндэсний төв	18	8	44.4
	Нийт			
	Тоо	191	70	
	Хувь	100	37	

Эмгэг судлалын үндэсний төв, Геронтологийн үндэсний төв, Цус сэлбэлт судлалын төвүүд нь нэвтрүүлсэн технологийн үнэлгээ хийдэг сайн талтай байхад Улсын гуравдугаар төв эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төв, Хавдар судлалын үндэсний төв нь үнэлгээ бараг хийдэггүй гэж хэлэхэд болохоор байна.

Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагууд шинээр нэвтрүүлсэн технологийн 161 буюу 84.3%-ийг байнга ашиглаж байна.

Хүснэгт 5. Технологийг нэвтрүүлснээс хойш байнга ашиглаж буй байдал

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Нэвтрүүлсэн	Үүнээс байнга
---	--------------------------------	-------------	---------------

		технологийн тоо	ашиглаж буй технологийн тоо	
			Тоо	Хувь
1	Улсын гуравдугаар төв эмнэлэг	54	34	63
2	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	18	16	89
3	Хавдар судлалын үндэсний төв	40	36	90
4	Геронтологийн үндэсний төв	15	15	100
5	Арьсны өвчин судлалын үндэсний төв	18	18	100
6	Эмгэг судлалын үндэсний төв	15	11	73.3
7	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	13	13	100
8	Халдварт өвчин судлалын үндэсний төв	18	18	100
Нийт	Тоо	191	161	
	Хувь	100	84.3	

Эрүүл мэндийн байгууллагууд нь технологийг нэвтрүүлснээс хойш байнга ашиглах байдал маш сайн буюу Геронтологийн үндэсний төв, Арьсны өвчин судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв зэрэг 4 эмнэлэг нэвтрүүлсэн бүх технологио байнга ашиглаж байна. Харин Улсын гуравдугаар төв эмнэлэгт нэвтрүүлсэн технологийн ашиглалтын байдал хамгийн бага буюу 63%-тай байлаа.

Технологийг нэвтрүүлснээр хэвтүүлэн эмчлүүлэгчдийн ор хоног буурах, гадаадад эмчлүүлэх шаардлагатай оношийн тоо буурах, үйлчлүүлэгчийн хөдөлмөрийн чадвар богино хугацаанд сэргэх, шинжилгээнд шаардлагатай хугацаа багасах, шинжилгээний аргачлал боловсронгуй болох зэрэг сайн талууд бүх эрүүл мэндийн байгууллагад ажиглагдсан байна. Эмчилгээ, үйлчилгээнд шинэ технологийг байнга ашиглахад эрүүл мэндийн салбарын санхүүжилт болон тоног төхөөрөмжийн дутмаг байдал бэрхшээл үүсгэж байна.

Үр дүн:

1. Нийт 8 эрүүл мэндийн байгууллагад сүүлийн 5 жилийн хугацаанд нийт 191 шинэ технологийг нэвтрүүлсэн байна.
2. Судалгаанд хамрагдсан байгууллагуудаас хамгийн олон технологи шинээр нэвтрүүлсэн байгууллага нь Улсын гуравдугаар төв эмнэлэг байсан ба 54 технологи нэвтрүүлсэн нь нийт нэвтрүүлсэн технологийн 28.3%-ийг эзэлж байна. Хавдар судлалын үндэсний төв 40 технологи шинээр нэвтрүүлжээ.
3. Шинээр нэвтрүүлсэн технологийн дийлэнх нь буюу 40,3% нь эмнэлгийн тоног төхөөрөмж, 24,1 % нь мэс заслын арга, 21,4 нь бусад (эмчилгээ, оношилгооны шинэ арга, үнэлгээний аргачлал, удирдлага, хяналтын тогтолцоо, заавар гм), 12,6% нь эмчилгээнд шинээр нэвтрүүлсэн эм байв.
4. Шинээр нэвтрүүлсэн технологийн талаас бага буюу дөнгөж 37%-д нь эрүүл мэндийн байгууллага үнэлгээ хийсэн ба үлдсэн 63%-д нь үнэлгээ хийлгүй практикт нэвтрүүлсэн сул тал ажиглагдаж байна.
5. Шинээр нэвтрүүлсэн нийт технологийн 161 буюу 84.3%-ийг нь өнөөг хүртэл практикт байнга ашиглаж байна.

6. Эрүүл мэндийн салбарын санхүүжилт болон тоног төхөөрөмжийн хязгаардагдмал байдал нь технологийг эмчилгээ үйлчилгээнд байнга хэрэглэхэд хүндрэл, бэрхшээл үүсгэдэг байна.